



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/10/НА-СТА-ОНӨА

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 7033-3019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.15 № 122
танай _____ -ны № _____ -т

ХАЙРХАН ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ А.ЦЭРЭНТОГТОХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулааны үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнэ тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулалгүйгээр төсөвт байгууллага, ААН, айл өрхөөс нийт 130,627.8 мянган төгрөгийн халаалтын орлого төвлөрүүлсэн.
- Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр 27,359.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

Дээрх зөрчлүүд нь Эрчим хүчний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг зөрчсөн, бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс дээгүүр, аудитын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ:		
1.10	Эргэлтийн хөрөнгө:		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	310,093.00
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	1,000.00
1.1.6	Бараа материал	-	11,153,650.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө БҮТЭЗ	-	7,398,150.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	18,862,893.00
1.20	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	27,168,145.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	27,168,145.00
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	46,031,038.00
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ:		
2.10	ӨР ТӨЛБӨР:		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	8,401,692.40
2.1.1.1	Дансны өглөг		8,000,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		-
2.1.1.3	Татварын өр	-	401,692.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	8,401,692.40
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.20	Өр төлбөрийн нийт дүн	-	8,401,692.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	37,629,345.60
2.3.11	Эздийн өмчийн дүн	-	37,629,345.60
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	-	46,031,038.00

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	130,627,782.00
2	Борлуулалтын өртөг	-	40,636,713.00
3	Нийт ашиг (алдагдал)	-	89,991,069.00
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		-
6	Ногдол ашгийн орлого		-
7	Хандив тусламжийн орлого		-
8	Бусад орлого		7,000,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	51,981,629.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал		-
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал		7,000,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-

Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-
17	Бусад ашиг (алдагдал)		-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	38,009,440.00
19	Орлогын татварын зардал	-	380,094.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	37,629,345.60
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	37,629,345.60
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
23.3	Бусад олз (гарз)		-
24	Орлогын нийт дүн	-	37,629,345.60
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	137,627,782.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		130,627,782.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	7,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	117,967,889.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	26,899,731.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	7,821,333.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	11,121,140.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	7,374,213.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	48,100,900.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	1,916,150.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		-
1.2.9	Бусад мөнгөн зарлага		14,734,422.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	19,659,893.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-

Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	19,349,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		19,349,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	(19,349,800.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	310,093.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	310,093.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-		-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			37,629,345.60	37,629,345.60
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	37,629,345.60	37,629,345.60

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 7,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Үүнд: Орлогын тайланд 7,000.0 мянган төгрөгийн орлого, зардлыг тусгаагүй тайлагнасныг санхүүгийн тайланд залрууллаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 164,987.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 4 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.1.1. Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулаан хангамжийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнэ тариф батлуулалгүйгээр 2022 онд 5 төсөвт байгууллага, 3 ААН, 16 айл өрхөөс нийт 130,627.8 мянган төгрөгийн халаалтын орлого бүрдүүлсэн байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хуулийн этгээд дараах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ", 12.1.2-т "Дулаан үйлдвэрлэх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэж, эрчим хүчний эх үүсвэрийг цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбох эрх олгоно", 13.2-т "Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан худалдах үнэ, нөхцөлийг дор дурдсанаас бусад тохиолдолд Зохицуулах хороогоор хянуулж батлуулна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага хүргүүлж, эрчим хүч хариуцсан улсын байцаагчид албан бичгээр шилжүүллээ.

3.1.2. Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр 27,359.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь аймгийн ИТХТ-ийн 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1-д "Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь батлагдсан төсвийн эх үүсвэр болон ажлын зайлшгүй шаардлагаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй эд хөрөнгө худалдан авах саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлж холбогдох шийдвэрийг гаргуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3. Хайрхан сумын ОНХС-аас сумын засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн "Хайрханы ирээдүй дэд хөтөлбөрт зардал гаргах тухай" А/180 дугаар захирамжаар дагуу тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх гэрээг байгуулан 7000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Тус ОНХС-ийн хөрөнгөөр иргэн С.Оюунтогтохоос ЕБС, хүүхдийн цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, ном, тоглоом зэргийг худалдан авсан бөгөөд ЕБС, цэцэрлэгт хүлээлгэн өгсөн баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.4. Хайрхан сумын ИТХ-ын 2022.09.16-ны өдрийн 07 дугаар тогтоолоор "Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сумын ЗДТГ-ын даргын албан тушаалтай М.Оюунцэцэгийг томилж ажиллуулсан нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.17-д "үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.....oOo.....

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	1	7000.0	1	7000.0			1	7000.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	4	164987.6	0	0	4	164987.6	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	1	0	0	0	1	0	0	0